



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/633

Булган сум

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн С.Ганбаяр /ГЙ79101810/-ийн Булган сум 6 дугаар баг Залуус 11 дүгээр гудамж 11086 тоотод байршилтай 6308002796 нэгж талбар бүхий амины орон сууцны зориулалтаар эзэмшиж буй 657 м2 газраас 315 м2 газрыг Б.Сэлэнгэ /ГИ87040500/-д шилжүүлэн, үлдсэн 342 м2 газрыг С.Ганбаяр /ГЙ87040500/-т, Л.Мөнхтөр /ЙР76121710/-ийн Булган сум 5 дугаар баг Д.Дамбын 2 дугаар гудамж 2086 тоотод байршилтай 6308009466 нэгж талбар бүхий үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 278 м2 газраас 114 м2 газрыг “Нүнжигт өргөө” ХХК /3191958/-д шилжүүлэн, үлдсэн 164 м2 газрыг Л.Мөнхтөрд, Г.Ганчулуун /ГЖ84120800/-ын Булган сум 6 дугаар баг Залуус 3 дугаар гудамж 307 тоотод байршилтай 6308004880 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 666 м2 газрын газар эзэмших эрхийг Д.Энхчимэг /ГГ87051907/-т тус тус эзэмшүүлсүгэй.

2. С.Ганбаяр, Б.Сэлэнгэ, Л.Мөнхтөр, “Нүнжигт өргөө” ХХК-ийн захирал, Д.Энхчимэг нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/323 дугаар захирамжийн Г.Ганчулуунтай холбогдох хэсэг, 2017 оны А/224 дүгээр захирамж, 2023 оны А/533 дугаар захирамжийн Л.Мөнхтөртэй холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

